



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/1/СТА-ТЭЗ

Цахим хуудас: orkhon.audit.mn Орхон аймаг 2020 он	Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас:70359826 Цахим хаяг: orkhon@audit.gov.mn Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитор: Г.Оргилмөрөн Утас: 70350757 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7
2.8.2 Авлага.....	9
2.8.3 Урьдчилгаа.....	11
2.8.4 Бараа материал	11
2.8.5 Нөөцийн бараа	12
2.8.6 Үндсэн хөрөнгө	13
2.8.7 Өр төлбөр.....	14
2.8.8 Засгийн газрын хувь оролцоо	16
2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	17
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	19
2.11. Шилэн дансны мэдээлэл	20
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	20
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	20
3. Менежментийн захидал	21
3.1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал	21
3.2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал	22
3.3. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....	22
3.4. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал	23
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	25
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	25
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	26
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	26
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	28
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	28
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	30

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
АО	Ажил олгогч
ЗДЗ	Засаг даргын захирамж
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ДТС	Дулаан түгээх сүлжээ
БТСХ	Биеийн тамир, спортын хороо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
УОО	Урьдчилж орсон орлого
ТАХОСС	Төрийн албан хаагчийн орон сууцны сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УТТО	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтыг газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

1. Аудитын гэрчилгээ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.04.20 № 101
танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
С.БАТЖАРГАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга С.Батжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

. Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Орхон аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах нь манай аймгийн эрхэм зорилго мөн” гэсэн байна.

Аймгийн удирдлага нь иргэддээ орон нутагтаа ажиллаж, амьдрах таатай орчныг бүрдүүлэх алсын хараатай ажиллана.

Орхон аймгийн ТЕЗ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн”.
- Төсвийн тухай хуулийн 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гол бодлогоо “Хүний хөгжил”-ийн асуудалд чиглүүлэн ажиллаж, хөгжилд хөтлөх 18 дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал: Эрдэнэтчүүд эрдэнэтчүүдтэй хайртай дэд хөтөлбөр, Багш, эмч дэд хөтөлбөр, Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр, Ач-санах дэд хөтөлбөр, Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж Орхон аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/557 дугаар захирамжаар баталсан байна. Уг НБББББ-г нэгтгэлд хамрагддаг байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлээгүй нь санхүүгийн тайланг бэлтгэх ба толилуулахад баримтлах зарчим, нэгтгэлд хамрагдах байгууллагуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг нэг журам, заавар, аргачлалаар бэлтгэхгүй, хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт нь харилцан адилгүй байх санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх зэрэг үр дагавартай байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Орхон аймгийн ТЕЗ-ын Санхүүгийн хяналт,

аудитын албыг Сангийн яамнаас стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, Засгийн газрын 2015 оны 483-р тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус алба 2020 онд төлөвлөгөөт 52, төлөвлөгөөт бус 2, нийт 54 байгууллагад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэсэн байна.

Эдгээр хяналт шалгалтаар 3,105.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах 68 албан шаардлага, 225 зөвлөмж хүргүүлэн, 40.6 сая төгрөгийн 27 нөхөн төлбөрийн акт тогтоосон ба үүнээс 3,018.9 сая төгрөгийн 65 албан шаардлагын биелэлтийг гаргуулж, 38.8 сая төгрөгийн нөхөн төлбөрийн актын биелэлт хангагдсан байна. Мөн өмнөх онуудын төлөгдөөгүй актын үлдэгдэл 4.5 сая төгрөгийн биелэлт хангагдсан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Орхон аймгийн ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Энэ нь Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ТШЗ-дын санхүүгийн тайлан, төсөл сан болон орон нутгийн өмчит ААН-үүдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэгтэй холбоотой юм.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Нийт хөрөнгийн 345,589.3 сая төгрөгийн 1 хувь буюу 3,455.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг Нийт хөрөнгийн 338,341.8 сая төгрөгийн 1 хувь буюу 3,383.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 3,383.4 сая төгрөгөөр тогтоосон нь төлөвлөлийн шатанд эхний хагас жилийн тайлангаас, гүйцэтгэлийн шатанд ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн жилийн эцсийн дүнгээс 1 хувиар материаллаг байдлыг тооцсонтой холбоотой болно.

2.8. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 32,725.5 сая төгрөг болж, өмнөх оноос 12.7 хувь буюу 3,684.4 сая төгрөгөөр өссөн байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2020 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Кассанд байгаа бэлэн мөнгө	0.2	0.0	0.8	0.0	0.6	0.0
Төгрөг	0.2	0.0	0.8	0.0	0.6	0.0
Банканд байгаа бэлэн мөнгө	29,040.8	100.0	32,724.7	100.0	3,683.8	12.7
Төгрөг	29,040.8	100.0	32,724.7	100.0	3,683.8	12.7
- Төрийн сангийн харилцах	28,194.5	97.1	32,074.5	98.0	3,879.9	13.4
- Арилжааны банк дахь харилцах	846.3	2.9	650.2	2.0	-196.1	-0.7
Нийт дүн	29,041.1	100.0	32,725.5	100.0	3,684.4	12.7
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		Үүнээс:		
		Дүн	Хувь	Касс	Төрийн сан	Арилжааны банк
- Төсөвт байгууллага	8,900.5	16,632.1	50.8	0.0	16,599.4	32.8
- Төрийн сан	19,402.6	15,583.6	47.6		15,475.1	108.5
- Төсөл сан	0.0	0.0	0.0			
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	738.0	509.7	1.6	0.8		508.9
Нийт дүн	29,041.1	32,725.5	100.0	0.8	32,074.5	650.2

Эх сурвалж: Орхон аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкин дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл 12.7 хувь буюу 3,683.8 сая төгрөгөөр, кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 0.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Төрийн сангийн харилцах 3,879.9 сая төгрөгөөр өсөж, арилжааны банкны харилцах 196.1 сая төгрөгөөр буурсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 1.6 хувийг ОНӨААН, 47.6 хувийг төрийн сан, 50.8 хувийг төсвийн байгууллагууд бүрдүүлж байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл банканд байгаа бэлэн мөнгөнөөс бүрдэж байна. Үүний 98.0 хувь нь төрийн сангийн харилцах, 2.0 хувь нь арилжааны банкны харилцах байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулбал төрийн сангийн мөнгөн хөрөнгө 3,818.9 сая төгрөгөөр, ОНӨААН-ийнх 228.3 сая төгрөгөөр тус тус буурсан, төсөвт байгууллагынх 7,731.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт мөнгөн хөрөнгийн өсөлтөд Эрдэнэт сангийн мөнгөн хөрөнгө /“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас орж ирсэн хамтын ажиллагааны хүрээн дэх 2,000.0 сая төгрөг болон Орхон аймаг дахь орон сууцны 1а хорооллын дэд бүтэц барих ажлын 12,500.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээнээс тайлант онд хэрэгжсэн гүйцэтгэлийн санхүүжилтийг олгож зарцуулагдаагүй үлдэгдлээр нэмэгдсэн/, барьцаа хөрөнгө, техник хяналтын зардлын дансны өсөлт гол нөлөө үзүүлсэн байна.

Төсөвт байгууллагын арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бол төрийн сангийн төрийн банкин дахь дансны үлдэгдэл 108.5 сая төгрөг байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг харуулбал.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
----------	----------------	-----------------	--------------------------	------------------

	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Банканд байгаа бэлэн мөнгө	19,402.6	100.0	15,583.6	100.0	-3,818.9	-19.7
<i>Төгрөг</i>	<i>19,402.6</i>	<i>100.0</i>	<i>15,583.6</i>	<i>100.0</i>	<i>-3,818.9</i>	<i>-19.7</i>
- Төрийн сангийн харилцах	19,297.6	99.5	15,475.1	99.3	-3,822.5	-19.7
- Арилжааны банк дахь харилцах	105.0	0.5	108.5	0.7	3.5	0.0
<i>Гадаад валют</i>	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
- Монголбанк	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт дүн	19,402.6	100.0	15,583.6	100.0	-3,818.9	-19.7

Эх сурвалж: Орхон аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсөвт татварын орлогоор 71,077.9 сая төгрөг бүрдүүлж, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын цэвэр санхүүжилтэд 1,926.6 сая төгрөг, орон нутгийн төсвийн байгууллагуудын урсгал санхүүжилтэд 54,521.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 19,778.0 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн сангийн Төрийн банкн дахь тусгай гэрээт байгууллагын харилцахын жилийн эцсийн үлдэгдэл оны эцэст 3.5 сая төгрөгийн хүүгийн орлого нэмэгдсэнээр 108.5 сая төгрөг болсон байна. Уг дансыг урьдчилж мөнгө гаргаж авах зэргээр кассын зориулалтаар ашигладаг бөгөөд тайлант онд тэтгэмж, тусламж, баяр наадмын зардалтай холбоотой нийт 40.3 сая төгрөгийн орлого зарлагын гүйлгээ дамжсан байна. Нэг удаагийн гүйлгээний дээд хэмжээ нь 11.4 сая төгрөг бөгөөд тэтгэмж олгох аймгийн ЗДЗ-аас 5.0 сая төгрөгөөр илүү зарлага гаргаж буцаан төвлөрүүлсэн зэргээр ашиглагдсан байна.
- ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангуулаагүй ажил гүйлгээг бүртгэсэн, бүртгэл, тайлагнал, баталгаажуулалт, санхүүгийн сахилга, хариуцлага, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 112.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 68.1 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 9.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 11.3 сая төгрөгийн албан шаардлага, 22.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

2.8.2 Авлага

Орхон аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 13,839.3 сая төгрөг байснаас тайлант онд 1,413.9 сая төгрөгөөр буюу 10.2 хувиар өсөж, оны эцэст 15,253.2 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөл- тийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Ажиллагчидтай холбогдсон авлага	13.4	0.1	34.0	0.2	20.7	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,985.3	14.3	1,978.7	13.0	-6.5	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дансны авлага /ТӨҮГ/	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	36.6	0.3	16.0	0.1	-20.6	-0.1
Байгууллагаас авах авлага	10,496.7	75.8	11,977.5	78.5	1,480.8	10.7
Хувь хүмүүсээс авах авлага	464.8	3.4	466.4	3.1	1.7	0.0
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	615.0	4.4	615.0	4.0	0.0	0.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	227.6	1.6	165.5	1.1	-62.0	-0.4
Нийт дүн	13,839.3	100.0	15,253.2	100.0	1,413.9	10.2
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	1,889.7	13.7	1,676.2	11.0	-213.6	-1.5
- Төрийн сан	746.2	5.4	744.7	4.9	-1.5	0.0
- Төсөл сан	221.2	1.6	220.9	1.4	-0.3	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	10,982.2	79.4	12,611.5	82.7	1,629.4	11.8
Нийт дүн	13,839.3	100.0	15,253.2	100.0	1,413.9	10.2

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс нийт авлагын эцсийн үлдэгдлийн 0.2 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага, 13.0 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 0.1 хувийг татвар, ндш-ын авлага /ТӨҮГ/, 78.5 хувийг байгууллагаас авах авлага, 3.1 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 4.0 хувийг засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл, 1.1 хувийг хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл тус тус бүрдүүлж байна.

Байгууллагаас авах авлага 1,480.8 сая төгрөг буюу 10.7 хувиар нэмэгдэж өмнөх онд нийт авлагын 75.8 хувийг эзэлж байсан бол тайлант онд 78.5 хувийг эзэлж байна. Авлага өссөнтэй холбоотойгоор зарим нэр төрлийн авлагын дүн нэмэгдсэн ч авлагын дүнд эзлэх хувь буурсан байна.

Байгууллагаас авах авлагын өсөлт нь орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдтэй холбоотой бөгөөд ихэнх хувь нь Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн авлага байна. Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ийн тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өр төлбөрийн өсөлттэй холбоотой албан шаардлагаа хүргүүлсэн байна.

Байгууллагын төрлөөр харвал авлагын эцсийн үлдэгдлийн 82.7 хувь буюу 12,611.5 сая төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн авлага, 11.0 хувь буюу 1,676.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын авлага, 4.9 хувь буюу 744.7 сая төгрөгийг төрийн сангийн авлага, 1.4 хувь буюу 220.9 сая төгрөгийг төсөл сангийн авлага тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлага 1.5 хувь буюу 213.6 сая төгрөгөөр, төрийн сангийн авлага 1.5 сая төгрөгөөр, төсөл сангийн авлага 0.3 сая төгрөгөөр буурсан боловч ОНӨААН-ийн авлага 11.8 хувиар буюу 1,629.4 сая төгрөгөөр өссөн байна. Авлагын ангиллаар авч үзвэл эдгээр нь ихэвчлэн байгууллагаас авах авлага болжээ.

Тайлант онд шинээр 127.3 сая төгрөгийн авлагыг төсвийн байгууллагууд үүсгэсэн байна. Тус авлагын өсөлтөд Жаргалант сумын ЗДТГ - 56.0 сая төгрөг, Хот тохижуулах газар - 25.7 сая төгрөг, аймгийн ЗДТГ - 23.1 сая төгрөг, БТСХороо - 13.6 сая төгрөгөөр авлага нэмэгдүүлсэн нь голчлон нөлөөлжээ. Үүнээс аймгийн ЗДТГ, БСТХорооны авлага нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлж авлага үүсгэсэн дүн байна.

Авлагын үлдэгдэлд тооцоо нийлсэн актгүй болон насжилт өндөртэй, бүрэн барагдахгүй, цаашид шийдвэрлэгдэхгүй байх үр дагавартай авлага оршин байна. Тухайлбал:

- 1996-1997 онуудад дампуурсан ХОТШ, даатгал банктай холбоотой орон нутгийн 9 байгууллагын 134.6 сая төгрөгийн найдваргүй авлага байна.
- Эрдэнэт сангийн 132.0 сая төгрөгийн он дамжсан авлага. Тайлант онд 12.0 сая төгрөгийн авлага төлөгдсөн.
- Их шүтээн цогцолборын 68.6 сая төгрөгийн он дамжсан авлага.

Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зээлийн хүрээнд арилжааны 3 банканд 615.0 сая төгрөгийн зээлийн авлага байна. Энэхүү зээл нь байнгын эргэлтэд ашиглагдаж байна.

ТЕЗ-ийн хоорондын тооцоотой холбоотой авлага, өр төлбөрийн 192.5 сая төгрөгийг устгах бичилт хийсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой НББ-ийн холбогдох стандарт, журам, зааврыг мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг хугацаанд нь барагдуулаагүй, СХС-ийн зээлийн авлагын мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлээгүй, хууль тогтоомж хэрэгжүүлээгүй зэрэг нийт 3,864.7 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 312.7 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 1,205.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, 2,346.4 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

2.8.3 Урьдчилгаа

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 56.7 сая төгрөг байснаас тайлант онд 54.0 сая төгрөгөөр буурч, оны эцэст 2.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Нийт урьдчилгаа дансны үлдэгдэлд урьдчилж гарсан зардал 100 хувийг эзэлж байна.

2.8.4 БАРАА МАТЕРИАЛ

Орхон аймгийн ТЕЗ-ийн бараа материалын эхний үлдэгдэл 5,952.8 сая төгрөг байснаас 727.3 сая төгрөгөөр өсөж, 6,680.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын үлдэгдлийг ангилал, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Түүхий эд материал	4,228.5	71.0	4,834.6	72.4	606.1	10.2
- Тусгай зориулалттай материал	4,191.1	70.4	4,720.2	70.7	529.1	8.9
- Эм боох материал	37.4	0.6	114.4	1.7	77.0	1.3
Дуусаагүй үйлдвэрлэл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	13.8	0.2	5.8	0.1	-8.0	-0.1
Хангамжийн материал	1,702.9	28.6	1,783.1	26.7	80.2	1.3
- Бичиг хэргийн материал	87.7	1.5	97.5	1.5	9.8	0.2
- Аж ахуйн материал	577.0	9.7	574.1	8.6	-2.9	0.0
- Сэлбэг хэрэгсэл	30.3	0.5	34.7	0.5	4.3	0.1
- Түлш, шатах тослох материал	11.7	0.2	56.9	0.9	45.3	0.8

- Барилгын засварын материал	75.3	1.3	113.2	1.7	37.9	0.6
- Хүнсний материал	27.0	0.5	36.6	0.5	9.6	0.2
- Бусад хангамжийн материал	893.9	15.0	870.1	13.0	-23.8	-0.4
Мал амьтад	7.6	0.1	56.6	0.8	49.0	0.8
Нийт дүн	5,952.8	100.0	6,680.1	100.0	727.3	12.2
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	5,170.1	87.0	5,918.1	88.6	748.0	12.6
- Төрийн сан		0.0		0.0	0.0	0.0
- Төсөл сан		0.0		0.0	0.0	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	782.7	13.0	762.0	11.4	-20.7	-0.3
Нийт дүн	5,952.8	100.0	6,680.1	100.0	727.3	12.2

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 11.4 хувь буюу 762.0 сая төгрөгийг орон нутгийн өмчит ААН, 88.6 хувь буюу 5,918.1 сая төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна.

Тайлант оны бараа материалын өсөлтөд түүхий эд материал 8.9 хувиар буюу 529.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Энэ нь тусгай зориулалтын материалын өсөлт буюу төсөвт байгууллагын бараа материалын өсөлт байна.

Тайлант онд нийт 727.3 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдан авсан 7,236.3 сая төгрөг, хандив, тусламжаар хүлээн авсан 665.9 сая төгрөг, шилжүүлэн авсан 636.4 сая төгрөг, бусад хэлбэрээр хүлээн авсан 1,019.7 сая төгрөг байна. Харин нийт 8,763.1 сая төгрөгийн бараа материал хасагдсаны 7,665.4 сая төгрөгийг худалдан зарцуулсан, 453.0 сая төгрөгийг шилжүүлсэн, 644.7 сая төгрөгийг бусад хэлбэрээр зарлагдсан байна.

Үүнээс ОНӨААН-үүд тайлант онд нийт 1,377.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,421.9 сая төгрөгийн бараа материал худалдан, зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлогоор тусгахгүй шууд зардлаар бүртгэсэн, бараа материалын нэр төрлийн хөдөлгөөний тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод хамруулаагүй, тушаал шийдвэргүй данс бүртгэлээс хассан, зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг нийт 384.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 294.1 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 85.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, 3.7 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

2.8.5 Нөөцийн бараа

Орхон аймгийн ТЕЗ-ийн нөөцийн барааны эхний үлдэгдэл 1.6 сая төгрөг байснаас 67.9 сая төгрөгөөр өсч, 69.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь өвс, тэжээлийн нөөц байна.

2.8.6 Үндсэн хөрөнгө

Орхон аймгийн ТЕЗ-ийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 282,749.6 сая төгрөг байснаас 0.3 хувиар буюу 761.2 сая төгрөгөөр өсөж, тайлант оны эцэст 283,510.8 сая төгрөг болсон байна.

Нийт хөрөнгийн 90.5 хувийг биет хөрөнгө, 9.5 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Газар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Биет хөрөнгө	256,575.0	90.7	256,604.8	90.5	29.8	0.0
Барилга, байгууламж	157,966.5	55.9	168,065.4	59.3	10,098.9	3.6
Авто тээврийн хэрэгсэл	2,905.5	1.0	2,587.5	0.9	-317.9	-0.1
Машин тоног төхөөрөмж	12,319.1	4.4	13,950.8	4.9	1,631.7	0.6
Тавилга эд хогшил	2,989.6	1.1	3,051.3	1.1	61.7	0.0
Зам, гүүрийн байгууламж	20,752.9	7.3	19,057.7	6.7	-1,695.3	-0.6
Түүх, соёл, музейн дурсгалт зүйлс	660.8	0.2	692.9	0.2	32.1	0.0
Бусад үндсэн хөрөнгө	16,420.4	5.8	19,673.2	6.9	3,252.8	1.2
Дуусаагүй барилга	42,287.0	15.0	29,224.7	10.3	-13,062.2	-4.6
Ном	273.3	0.1	301.2	0.1	28.0	0.0
Биет бус хөрөнгө	26,174.6	9.3	26,906.0	9.5	731.4	0.3
Программ хангамж	423.4	0.1	376.0	0.1	-47.4	0.0
Бусад биет бус хөрөнгө	25,751.2	9.1	26,530.0	9.4	778.8	0.3
Нийт дүн	282,749.6	100.0	283,510.8	100.0	761.2	0.3
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	229,987.7	81.3	227,637.0	80.3	-2,350.7	-0.8
- Төрийн сан		0.0		0.0	0.0	0.0
- Төсөл сан		0.0		0.0	0.0	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	52,761.9	18.7	55,873.8	19.7	3,111.9	1.1
Нийт дүн	282,749.6	100.0	283,510.8	100.0	761.2	0.3

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны үндсэн хөрөнгийн дансны цэвэр өсөлт 14,389.8 сая төгрөг, хуримтлагдсан элэгдлийн цэвэр бууралт 13,628.6 сая төгрөг буюу хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр нийт үндсэн хөрөнгө 761.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.


Энэ нь улс орон нутгийн төсвийн хөрөнгө, ОНХС-аар бэлтгэсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байна. Тухайлбал: Шинээр баригдсан Залуучуудын ордон, 23-р цэцэрлэг, 11-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 7-р цэцэрлэгийн бассейны барилга, тоног төхөөрөмж, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн камержуулалт, тоног төхөөрөмж, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн бүтээн байгуулалтын ажлууд, Жаргалант сумын сургуулийн хүүхдийн дотуур байрны барилга, аймаг, сумдын гэрэлтүүлэг, зам талбайн барилга, байгууламжууд байна.

Нийт хөрөнгийн дүнд төсвийн байгууллагын хөрөнгө 80.3 хувь буюу 227,637.0 сая төгрөгийг, ОНӨААН-үүдийн хөрөнгө 19.7 хувь буюу 55,873.8 сая төгрөгийг эзэлж байна. Төсвийн байгууллагуудын хөрөнгө тайлант онд 0.8 хувь буюу 2,350.7 сая төгрөгөөр буурч, ОНӨААН-үүдийн үндсэн хөрөнгө 3,111.9 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна.

Хөрөнгийн ангиллаар харвал биет хөрөнгө 29.8 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 731.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 59.3 хувийг барилга, байгууламж, 6.7 хувийг зам, гүүрийн байгууламж, 6.9 хувийг бусад үндсэн хөрөнгө, 10.3 хувийг дуусаагүй барилга, байгууламж, 1.1 хувийг тавилга, эд хогшил, 4.9 хувийг машин, тоног төхөөрөмж, 0.9 хувийг тээврийн хэрэгсэл, 0.2 хувийг түүх, соёл, музейн дурсгалт зүйлс, 9.5 хувийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө худалдан авсан 822.5 сая төгрөг, хандиваар авсан 1,162.6 сая төгрөг, шилжүүлэн авсан 13,196.6 сая төгрөг, бусад 23,338.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, худалдсан 263.9 сая төгрөг, акталсан 1,214.8 сая төгрөг, шилжүүлсэн 772.8 сая төгрөг, бусад 21,878.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 29,848.0 сая төгрөгийн он дамжин хэрэгжих бүрэн ашиглалтад ороогүй барилга, зам, засварын ажлуудын хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, зөрүүтэй бүртгэсэн, хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, үндсэн хөрөнгийн элзэгдлийг зөрүүтэй тооцсон, зэрэг нийт 42.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 35.5 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, алдаа зөрчлийг дахин давтахгүй байх 9 зөвлөмж, 6.7 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр оны эхэнд 28,931.5 сая төгрөг байснаас тайлант онд 9,566.2 сая төгрөгөөр өсөж, 38,497.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт/ (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		

Богино хугацаат өр төлбөр	16,983.9	58.7	25,648.8	66.6	8,664.9	29.9
Богино хугацаат зээлийн өглөг	40.3	0.1	36.7	0.1	-3.6	0.0
Өглөг	20.0	0.1	70.4	0.2	50.5	0.2
- Ажилчидтай холбогдсон өглөг	15.2	0.1	22.4	0.1	7.2	0.0
- Бараа, үйлчилгээний зардлын өглөг	4.8	0.0	43.2	0.1	38.4	0.1
- Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	0.0	0.0	4.9	0.0	4.9	0.0
Бусад өглөг	13,966.3	48.3	15,736.6	40.9	1,770.2	6.1
- Байгууллагад төлөх өглөг	4,931.3	17.0	5,817.1	15.1	885.8	3.1
- Хувь хүмүүст төлөх өглөг	0.6	0.0	2.0	0.0	1.4	0.0
- Татварын өглөг /ТӨҮГ/	29.0	0.1	41.7	0.1	12.6	0.0
- НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	5.6	0.0	4.8	0.0	-0.8	0.0
- Дансны өглөг /ТӨҮГ/	8,999.8	31.1	9,871.0	25.6	871.2	3.0
Урьдчилж олсон орлого	2,957.3	10.2	9,805.0	25.5	6,847.7	23.7
- Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	2,319.4	8.0	9,317.8	24.2	6,998.4	24.2
- Бусад урьдчилж орсон орлого	637.9	2.2	487.2	1.3	-150.7	-0.5
- Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар		0.0		0.0	0.0	0.0
Урт хугацаат өр төлбөр	11,947.6	41.3	12,849.0	33.4	901.4	3.1
- Хойшлогдсон өр төлбөр	4,500.9	15.6	5,402.3	14.0	901.4	3.1
- Төслийн зээл /ТӨҮГ/	7,446.7	25.7	7,446.7	19.3	0.0	0.0
Нийт дүн	28,931.5	100.0	38,497.7	100.0	9,566.2	33.1
Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт/ (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	6,626.7	22.9	14,773.7	38.4	8,147.1	28.2
- Төрийн сан	7,865.4	27.2	7,620.6	19.8	-244.8	-0.8
- Төсөл сан	221.2	0.8	220.9	0.6	-0.3	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	14,218.3	49.1	15,882.6	41.3	1,664.3	5.8
Нийт дүн	28,931.5	100.0	38,497.7	100.0	9,566.2	33.1

Эх сурвалж: Орхон аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрт урт хугацаат өр төлбөр 12,849.0 сая төгрөг буюу 33.4 хувийг, богино хугацаат өр төлбөр 25,648.8 сая төгрөг буюу 66.6 хувийг тус тус эзэлж байна. Тайлант онд БХӨТ 8,664.9 сая төгрөг буюу 29.9 хувиар, урт хугацаат өр төлбөр 901.4 сая төгрөг буюу 3.1 хувиар тус тус өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр

БХӨТ-ийн өсөлтөд урьдчилж олсон орлого 6,847.7 сая төгрөгөөр, бусад өглөг 1,770.2 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Бусад өглөгийн өсөлт нь дансны өглөг /ТӨҮГ/-ийн 871.2 сая төгрөг, байгууллагад төлөх өглөгийн 885.8 сая төгрөгийн өсөлттэй холбоотой бол урьдчилж орсон орлого нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас орж ирсэн 14,500.0 сая төгрөгийн он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 8,369.0 сая төгрөгөөр урьдчилж орсон орлого данс нэмэгдэж, өмнөх онуудын тайлант онд хэрэгжсэн 1,370.3 мянган төгрөгийг орлогоор хүлээн

зөвшөөрч бүртгэж тайлант онд урьдчилж орсон орлого данс 6,998.7 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эрдэнэт сан 9,097.0 сая төгрөг / Эрдэнэт үйлдвэртэй хамтын ажиллагааны гэрээний дагуу орж ирсэн УОО/, ТАХОССан 220.8 сая төгрөг, “Эрдэнэт – Ус ДТС” ОНӨААН 487.2 сая төгрөгийн УОО тус тус бүртгэсэн байна.

Тайлант онд байгууллагад төлөх өглөг 885.8 сая төгрөгөөр, татварын өглөг /ТӨҮГ/ 12.6 сая төгрөгөөр, дансны өглөг /ТӨҮГ/ 871.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 38.4 сая төгрөгөөр, ажилчидтай холбогдсон өглөг 7.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Богино хугацаат өр төлбөрийн байгууллагад төлөх өглөгийн үлдэгдэлд 4,306.1 сая төгрөгийн ОНХО-н дансны, 47.9 сая төгрөгийн ОНХС-ийн дансны, 1,132.8 сая төгрөгийн сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр, 143.3 сая төгрөгийн төсвийн байгууллагын өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр

Хойшлогдсон өр төлбөр: Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд “Эрдэнэт – Ус ДТС”-ОНӨХК-ийн 5,402.3 сая төгрөгийн ОНХО-аар хийсэн зам талбайн гэрэлтүүлгийг хойшлогдсон орлогоор бүртгэсэн шалтгаанаар үүссэн өр байна. Байгуулсан элэгдлээрээ нөхөгддөг.

Төслийн зээл: МОН-23 төслийн зээлийн өглөг 7,446.7 сая төгрөг орон нутгийн өр төлбөрт бүртгэлтэй байдаг байна. Энэ нь орон нутагт гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, төвлөрсөн системд холбож, худаг гаргахад зориулан Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн зээлийн өглөг байна. Тайлант онд Сангийн яамны санхүүгийн бодлогын газартай тооцоо нийлсэн актаар хуримтлагдсан хүүгийн, хугацаа хэтэрсэн үндсэн зээлийн болон хүүгийн төлбөр тооцсон байна.

Аудитын илрүүлэлт:

- ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар өглөгийн данстай холбоотой өглөгийг буруу бүртгэсэн, бараа, ажил үйлчилгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, хууль тогтоомж зөрчсөн, үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг нийт 6,629.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. **Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчилд 38.2 сая төгрөгийн алдааг дахин давтахгүй байх зөвлөмж, 271.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 6,320.1 сая төгрөгийн залруулга хийсэн бөгөөд холбогдох байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нийт хэмжээ тайлант оны эхэнд 302,709.6 сая төгрөг байснаас 0.9 хувь буюу 2,865.6 сая төгрөгөөр буурч 299,844.0 сая төгрөгт хүрсэн байна.

Засгийн газрын хувь оролцооны бүтцийг авч үзвэл, Засгийн газрын оруулсан капитал 41.5 хувь буюу 124,409.0 сая төгрөг, дахин үнэлгээний нөөц 27.2 хувь буюу 81,584.6 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 31.3 хувь буюу 93,850.5 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл. /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Засгийн газрын оруулсан капитал	120,350.8	39.8	124,409.0	41.5	4,058.2	1.3
Дахин үнэлгээний нэмэгдэл	81,615.9	27.0	81,584.6	27.2	-31.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	100,742.9	33.3	93,850.5	31.3	-6,892.4	-2.3
Нийт дүн	302,709.6	100.0	299,844.0	100.0	-2,865.6	-0.9

Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	251,639.9	83.1	245,866.8	82.0	-5,773.1	-1.9
- Төрийн сан		0.0		0.0	0.0	0.0
- Төсөл сан		0.0		0.0	0.0	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	51,069.7	16.9	53,977.2	18.0	2,907.5	1.0
Нийт дүн	302,709.6	100.0	299,844.0	100.0	-2,865.6	-0.9

Эх сурвалж: Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга нь 14 байгууллагын өмнөх үеийн үр дүн дансанд бүртгэсэн бичилт, залруулгын дүнд 7.4 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 83 төсвийн байгууллага, 7 ОНӨААН, 2 төрийн сан /аймаг, жаргалант сум – тусдаа нэгтгэсэн тайлан гардаггүй/ нийт 92 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс /Өрхийн эмнэлэг, хувийн сургууль, хувийн цэцэрлэг, Ахмадын хороо, УТХО, УТТО, ТАХОСС, Нээгдээгүй байгууллага, ЕБС-ийн ТЗШ-ийн хэмнэлт, СӨБ-ийн ТЗШ-ийн хэмнэлт зэрэг данс ороод 102 байгууллага/, 83 төсвийн байгууллага, 8 ӨЭМТ, 7 ОНӨААН, ТЕЗ ороод нийт 99 байгууллага аудитад хамрагдсан байна.

Хүснэгт №9. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр (тоогоор)					
		Санал дүгнэлт гаргасан			Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Нийт дүн
		ТАБ	ХАК	Нийт			
1	Төсвийн шууд захирагч	51	17	68	12	11	91
2	ОНӨААН	3	2	5	2		7
3	ТЕЗ	1		1			1
	Дүн	55	19	74	14	11	99
	Дүнд эзлэх хувь	55.6	19.2	74.8	14.1	11.1	100.0

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 14 байгууллагыг түүвэрт хамруулж, 11 байгууллагад итгэл үзүүлж, 74 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” - 65, “Хязгаарлалттай” - 8 /Үүнд: Эрдэнэт сан, Нийцэл ӨЭМТ, Мэндцэцэн ӨЭМТ, 4-р цэцэрлэг, Мөнхийн гэгээ ӨЭМТ, Жаргалант сумын ЗДТГ, Мөнхсүндрэл ӨЭМТ, Их шүтээн цогцолбор ОНӨААН/, “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” - 1 /Үүнд: Учралтбаяр ӨЭМТ/ дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт №10. Санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	Дүн
1	ТШЗ	60	7		1	68
2	ОНӨААН	4	1			5
3	ТЕЗ	1				1
	Дүн	65	8	0	1	74

Дүнд эзлэх хувь	87.8	10.8	0	1.4	100.0
-----------------	------	------	---	-----	-------

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 90,316.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 78,962.7 сая төгрөгийн алдааг залруулж, 49.5 сая төгрөгийн зөрчилд 44 төлбөрийн акт тогтоож, 3,460.2 сая төгрөгийн зөрчилд 81 албан шаардлага, 7,844.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 156 зөвлөмж өглөө.

Хүснэгт №11 Алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийн байдал (сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТЕЗ	4	339.8	5	45,550.7	9	45,890.5	5	45,550.7
2	ТШЗ	253	5,521.4	64	30,357.5	317	35,878.9	64	30,357.5
3	ОНӨААН	24	5,492.5	5	3,054.5	29	8,547.0	5	3,054.5
	Дүн	281	11,353.7	74	78,962.7	355	90,316.4	74	78,962.7

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Хүснэгт №12

(сая.төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТЕЗ	4	339.8	-	-	-	-	4	339.8	-	-	-	-
2	ТШЗ	253	5,521.4	42	49.2	76	1,192.1	135	4,280.1	-	-	-	-
3	ОНӨААН	24	5,492.5	2	0.3	5	2,268.1	17	3,224.1	-	-	-	-
	Дүн	281	11,353.7	44	49.5	81	3,460.2	156	7,844.0	-	-	-	-

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 37.61 сая төгрөгөөр авлагыг дутуу, 37.79 сая төгрөгөөр бараа материалыг илүү, Урт хугацаат хөрөнгө оруулалтын 100.0 сая төгрөгийг ангилал алдаатай, өглөгийг 5.0 сая төгрөгөөр дутуу, хуримтлагдсан үр дүнг 5.2 сая төгрөгөөр илүү, Эзний өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/-ийн 39,250.1 сая төгрөгийг нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/ дансанд нэгтгэсэн;

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийтлэг татварын бус орлогыг 0.2 сая төгрөгөөр, тусламж, санхүүжилтийн орлогыг 23.4 сая төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 0.9 сая төгрөгөөр, АО-с төлөх НДШ-ийн зардлыг 0.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 27.5 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 3.9 сая төгрөгөөр, нормативт зардлыг 727.2 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 43.9 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8.5 сая төгрөгөөр тус тус дутуу, урсгал шилжүүлгийг 727.2 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардлыг 42.7 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;

- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг 13.4 сая төгрөгөөр илүү, 18.6 сая төгрөгөөр тайлант үеийн үр дүнг дутуу нэгтгэсэн;

